



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.12.03 № 10/153

ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 18.5 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.8 дугаар зүйлд заасан цаглаварын дагуу энэхүү аудитыг “Б энд С аудит” ХХК гүйцэтгэлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 624.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15кв-ын ЦДАШ дэд станцыг Өвөрхангай аймгийн Уянга сумын Бадрал жаргалант багт барихаар “Эрдэнэт Булганы ЦТС” ТӨХК, ЭХЗГазартай гэрээ байгуулжээ. Компаний ерөнхий инженерээр ажиллаж байсан Ц.Ганбат, хүргэн Эрдэнэжаргалын “БЭЕТ” ХХК-тай материал бэлтгэх гэрээг байгуулан 375.2 сая төгрөг шилжүүлсэн боловч материалыг орлогод бүртгээгүй, авлага өглөгийн тооцоонд үлдэгдлээр харуулаагүй, нотлох баримтгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 4.1.2-д “Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих” гэж заасныг үндэслэн материалыг орлогод авч, гүйцэтгэлийг гарган 2014 оны 3 дугаар сарын 1-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус компаний Эдийн засгийн асуудал эрхэлсэн дэд захирал, ерөнхий нягтлан бодогч Х.Жаргаланбаатар, ахлах нягтлан бодогч Л.Оюунчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР**

**“Б ЭНД С АУДИТ” ХХК-ИЙ
ЗАХИРАЛ**

ЗӨВШӨӨРСӨН:

**ЭБЦТС” ТӨХК-ИЙ ЭДИЙН ЗАСГИЙН
АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ,
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ**

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ



Л.ОДГЭРЭЛ

Д.ДАШХОРЛОО



Х.ЖАРГАЛАНБААТАР

Л.ОЮУНЧИМЭГ